



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/80

Батноров сум

Буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эхэнбүрд 2 дугаар багийн унаган хүү аймгийн харцага Цэцгээ овогтой Өнөрбат нь Архангай аймгийн Ара комплекс-д зохион байгуулагдах Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд -90 кг-ийн жинд эх орноо төлөөлөн оролцох эрх авсан тул 2025 оны 05 дугаар сарын 10-аас 06 дугаар сарын 06-ны өдрүүдэд ОХУ-ын Саха-Якут хотноо олон улсын шигшээ багын тамирчидтай тэмцээний бэлтгэл хангахаар Монгол улсаас Якутск хотыг зорино. Иймд бэлтгэлийн санхүүжилтэд нь дэмжлэг үзүүлж 600.000 (Зургаан зуун мянган) төгрөгийн буцалтгүй тусламж олгосугай.

2.Буцалтгүй тусламж болох 600.000 (Зургаан зуун мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Б.Энхжаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА  ГӨТГОНБАЯР

280425180